



ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТАВИЛГА ЭД ХОГШИЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № ХСТТ-16/01-4

Багц-4 Цахилгаан бараа нийлүүлэх

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яамны харъяа Хавдар Судлалын Үндэсний төв (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Хасу энержи интернэшнл" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 11 сарын 07-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.2-р зүйлийг үндэслэн холбогдон захиалагч, нийлүүлэгч хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

2. Нийлүүлэгч нь тендер шалгаруулалтын 4-р багцыг нийт **92,210,000** /Ерэн хоёр сая хоёр зуун арван мянган төгрөг/-р нийлүүлнэ.  
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас: 2016 онд: **92,210,000** /Ерэн хоёр сая хоёр зуун арван мянган төгрөг/
3. Нийлүүлэгч нь захиалгыг захиалсан тоо хэмжээ, загвар, чанар, хүчин чадлын хувьд захиалагчийн хэрэгцээнд нийцсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний бичиг баримт" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай бичиг баримт;  
Тендер ба үнийн хуваарь;  
Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаархи талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5. Захиалагч, нийлүүлэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

##### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Хавдар Судлалын Үндэсний Төв

ХҮИТА-ны дарга

С.Эрдэнэбаатар

Ерөнхий нягтлан бодогч

Х.Нарантуяа

Хаяг: Хавдар судлалын үндэсний төв  
Баянзүрх дүүрэг, 18-р хороо  
Нам Янг Жугийн гудамж  
Улаанбаатар хот,  
Утас/факсны дугаар: 11-450043, 11-458189  
Харилцагч банкны нэр, дансны дугаар:  
Төрийн сан: 900020019

##### НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:

Хасу энержи интернэшнл ХХК



Ерөнхий менежер

Б.Ууганбаатар

Нягтлан бодогч

Х.Бямбасүрэн

Хаяг: Хасу бизнес төв-3, 18-р хороо 14/3,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот,  
Утас/факсны дугаар: 77223344, 77229944  
Харилцагч банкны нэр, дансны дугаар:  
Хаан банк: 5028623858  
Регистер: 5113881, Цахим хаяг: info@khasu.mn

#### ЗӨВШӨӨРСӨН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ САНХҮҮ,  
ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.БАЯРСАЙХАН